



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 12-дээр

Дугаар 41

Мандалговь


Г

Т

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.8.а дахь заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 09 дүгээр тогтоолоор балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн боловч орон нутгийн өмчид бүртгэлгүй явж ирсэн 39-28 ДУА улсын дугаартай УАЗ-31519 маркын автомашины дуудлагын худалдааны доод үнийг 1,800,000 /нэг сая найман зуун мянган/ төгрөгөөр тогтоож худалдахыг зөвшөөрсүгэй.
2. Дуудлагын худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогоос автомашины татварын тооцоог барагдуулж үлдэгдлийг Төрийн сангийн хөрөнгө худалдсаны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.



0160105

15